



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Аудитын код: САГ-2021/08/СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням: Утас: 260949 Цахим хаяг:sambuunyamyia@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас:261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: А.Даваадорж Утас:261628 Цахим хаяг:davaadorja@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ц.Цэрэнхүү Утас:261628 Цахим хаяг:tserenkhuits@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Мөнхчимэг Утас:261628 Цахим хаяг:munkhchimegq@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө	15
3.5.3 Авлага	16
3.5.4 Урьдчилгаа	16
3.5.6 Бараа материал	17
3.5.7 Үндсэн хөрөнгө	18
3.5.8 Өр төлбөр	19
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	21
3.8 Аудитын гол асуудал	21
3.9 Шилэн дансны мэдээлэл	21
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт	22
Албан шаардлага	22
Зөвлөмж	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АЖХТ	Аялал жуулчлалын хөгжлийн төв
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДЦГХЗ	Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОББҮХ	Орчны бохирдлын бууруулах үндэсний хөтөлбөр
ОСХТ	Ойн судалгаа, хөгжлийн төв
СГЗ	Сав газрын захиргаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УТХГЗ	Улсын тусгай хамгаалалтын газрын захиргаа
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦУОШТ	Цаг уур, орчны шинжилгээний төв
ЭХЯ	Эрчим хүчний яам



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Н.УРТНАСАН ТАНАА

2021.04.26 № 1333

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 14,865.5 сая төгрөгийн залруулаагүй дараах алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал”, “ Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp contains some faint, illegible text.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,440,382.9	103,633,658.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,403,893.8	19,140,140.4
33	АВЛАГА	3,825,091.6	2,138,459.0
34	УРЬДЧИЛГАА	29,720,288.0	27,516,926.9
35	БАРАА МАТЕРИАЛ	9,405,518.5	13,346,008.1
36	НӨӨЦИЙН БАРАА	1,520.0	2,774.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	28,084,071.0	41,489,350.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,876,003.9	75,295,405.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,876,003.9	75,295,405.5
39200	Биет хөрөнгө	45,878,782.1	58,093,985.9
39300	Биет бус хөрөнгө	16,997,221.8	17,201,419.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	151,316,386.8	178,929,064.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,757,704.6	19,129,217.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,757,704.6	19,129,217.1
41300	Өглөг	614,328.9	825,920.7
41400	Урьдчилж орсон орлого	17,143,375.8	18,303,296.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	133,558,682.1	159,799,846.9
51	Засгийн газрын хувь оролцоо	133,558,682.1	159,799,846.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	43,627,246.9	43,900,092.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	8,087,190.4	7,910,927.9
51200	Хуримтлагдсан үр дүн	75,235,547.3	101,429,947.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,608,697.5	6,558,879.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	151,316,386.8	178,929,064.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	151,776,320.4	158,342,374.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,652,345.5	26,709,170.6
120	Нийтлэг татварын бус орлого	14,652,345.5	26,709,170.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	137,123,974.9	131,633,203.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	84,025,805.2	121,070,040.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,119,624.4	121,070,040.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,468,265.6	99,221,625.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,885,827.7	36,123,648.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,616,992.3	4,697,994.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,397,882.6	1,641,647.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,074,670.1	2,923,405.0
2105	Норматив зардал	61,686.8	132,338.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	845,241.8	983,383.2
2107	Томилолт, зочны зардал	657,257.8	587,819.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,960,745.4	38,040,295.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,967,961.0	14,091,092.0
212	ТАТААС	10,000,000.0	15,851,028.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,651,358.8	5,997,387.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,906,180.7	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	67,750,515.2	37,272,333.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	1,647,116.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,371,866.9	175,131.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	46,378,648.3	38,744,318.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,137,314.4	-	91,137,314.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,952,758.4)	-	(3,952,758.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	87,184,556.0	-	87,184,556.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(35,445.1)	-	(35,445.1)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	30,922.9	-	30,922.9
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	46,378,648.3	-	46,378,648.3
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	133,558,682.1	-	133,558,682.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(12,375,809.7)	-	(12,375,809.7)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,182,872.4	-	121,182,872.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(49,818.6)	-	(49,818.6)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	272,845.6	-	272,845.6
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	(329,171.0)	-	(329,171.0)
18	Зарласан ногдол ашиг	(21,200.0)	-	(21,200.0)
19	Тайлант үеийн үр дүн	38,744,318.4	-	38,744,318.4
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,799,846.9	-	159,799,846.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	143,648,089.5	139,739,225.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,081,451.4	3,005,256.1
120	Нийтлэг татварын бус орлого	3,081,451.4	3,005,256.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	140,566,638.1	136,733,969.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,873,870.5	128,398,507.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,873,870.5	128,398,507.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,483,247.5	104,675,956.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,034,142.0	35,945,882.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,716,386.2	4,749,249.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,521,694.0	1,662,493.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,317,602.3	2,012,359.5
2105	Норматив зардал	99,489.9	113,152.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,398,577.6	3,641,279.8
2107	Томилот, зочны зардал	544,383.2	436,819.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,078,989.6	47,234,251.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,771,982.8	8,880,468.5
212	ТАТААС	10,000,000.0	15,851,028.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,390,622.9	7,871,522.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55,774,219.0	11,340,718.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	22,880.3	22,374.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,759,507.7	9,625,827.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,759,507.7	9,625,827.7
2200	Дотоод эх үүсвэрээр	11,759,507.7	9,625,827.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(11,736,627.5)	(9,603,453.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(42,917,094.8)	(1,018.2)
14	Бусад эх үүсвэр	36,998.0	20,181.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	42,954,092.9	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	21,200.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,120,496.8	1,736,246.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,283,397.1	17,403,893.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,403,893.8	19,140,140.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,769,265,400.00	132,500,037,042.57	25,269,228,357.43	84.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,671,229,700.00	116,386,503,750.57	22,284,725,949.43	83.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,303,033,700.00	97,245,649,542.31	22,057,384,157.69	81.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,975,579,400.00	34,085,083,307.36	890,496,092.64	97.5
210101	Үндсэн цалин	24,261,734,000.00	23,661,581,869.30	600,152,130.70	97.5
210102	Нэмэгдэл	8,881,054,100.00	8,669,334,902.63	211,719,197.37	97.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,526,283,700.00	1,487,605,770.68	38,677,929.32	97.5
210105	Гэрээт ажлын хөлс	306,507,600.00	266,560,764.75	39,946,835.25	87.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,718,530,500.00	4,456,906,630.56	261,623,869.44	94.5
210201	Тэтгэврийн даатгал	3,305,836,300.00	3,080,922,268.39	224,914,031.61	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	353,173,800.00	344,920,886.10	8,252,913.90	97.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	282,484,200.00	276,711,420.86	5,772,779.14	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	70,689,200.00	68,713,511.44	1,975,688.56	97.2
210205	Эрүүл мэндийн даатгал	706,347,000.00	685,638,543.77	20,708,456.23	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,660,255,900.00	1,608,895,985.61	51,359,914.39	96.9
210301	Гэрэл, цахилгаан	576,990,400.00	543,839,716.18	33,150,683.82	94.3
210302	Түлш, халаалт	746,329,100.00	741,988,765.35	4,340,334.65	99.4
210303	Цэвэр, бохир ус	71,494,500.00	66,734,872.90	4,759,627.10	93.3
210304	Байрны түрээс	265,441,900.00	256,332,631.18	9,109,268.82	96.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,405,059,200.00	1,362,761,476.79	42,297,723.21	97.0
210401	Бичиг хэрэг	135,869,300.00	130,151,867.00	5,717,433.00	95.8
210402	Тээвэр, шатахуун	922,802,200.00	895,769,320.50	27,032,879.50	97.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	237,290,000.00	230,806,728.29	6,483,271.71	97.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,724,700.00	3,498,800.00	225,900.00	93.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	105,373,000.00	102,534,761.00	2,838,239.00	97.3
2105	Нормативт зардал	72,544,500.00	72,008,004.00	536,496.00	99.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,590,100.00	36,576,500.00	13,600.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,954,400.00	35,431,504.00	522,896.00	98.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,235,053,400.00	3,204,289,512.01	30,763,887.99	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,127,221,900.00	3,099,979,920.01	27,241,979.99	99.1

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,159,200.00	23,775,880.00	383,320.00	98.4
210604	Урсгал засвар	83,672,300.00	80,533,712.00	3,138,588.00	96.2
2107	Томилолт, зочны зардал	291,986,600.00	258,285,590.00	33,701,010.00	88.5
210702	Дотоод албан томилолт	291,986,600.00	258,285,590.00	33,701,010.00	88.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,557,229,400.00	44,839,257,033.98	13,717,972,366.02	76.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,840,687,500.00	44,144,912,318.68	13,695,775,181.32	76.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,950,100.00	31,173,080.00	1,777,020.00	94.6
210803	Даатгалын үйлчилгээ	36,734,300.00	34,487,361.00	2,246,939.00	93.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,526,000.00	415,172,942.20	1,353,057.80	99.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	4,895,300.00	4,135,400.00	759,900.00	84.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	141,228,500.00	140,230,934.00	997,566.00	99.3
210807	Газрын төлбөр	45,329,000.00	30,368,863.10	14,960,136.90	67.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	368,700.00	269,665.00	99,035.00	73.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,510,000.00	38,506,470.00	3,530.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,386,794,800.00	7,358,162,002.00	7,028,632,798.00	51.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,264,176,400.00	7,286,138,921.00	6,978,037,479.00	51.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,618,400.00	72,023,081.00	50,595,319.00	58.7
212	ТАТААС	15,851,030,000.00	15,851,028,180.00	1,820.00	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15,851,030,000.00	15,851,028,180.00	1,820.00	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15,851,030,000.00	15,851,028,180.00	1,820.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,517,166,000.00	3,289,826,028.26	227,339,971.74	93.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	371,222,200.00	194,550,480.90	176,671,719.10	52.4
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	371,222,200.00	194,550,480.90	176,671,719.10	52.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,145,943,800.00	3,095,275,547.36	50,668,252.64	98.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,285,500.00	46,085,500.00	200,000.00	99.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,250,000.00	8,250,000.00	-	100.0

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,091,408,300.00	3,040,940,047.36	50,468,252.64	98.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,098,035,700.00	16,113,533,292.00	2,984,502,408.00	84.4
220001	Барилга байгууламж	17,439,400,000.00	14,655,285,878.00	2,784,114,122.00	84.0
221001	Их засвар	200,000,000.00	-	200,000,000.00	0.0
223001	Бусад хөрөнгө	1,458,635,700.00	1,458,247,414.00	388,286.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,769,265,400.00	132,726,553,271.55	25,042,712,128.45	84.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,473,761,600.00	132,024,402,323.57	25,449,359,276.43	83.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	157,473,761,600.00	132,024,402,323.57	25,449,359,276.43	83.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	295,503,800.00	701,550,947.98	(407,247,147.98)	237.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,453,800.00	370,962,692.84	(104,508,892.84)	139.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,050,000.00	330,588,255.14	(301,538,255.14)	1,140.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,000.00	(1,000.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000.00	(1,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	5,837	5,945	(108)	101.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	81	81	-	100.0
610001	Төсвийн байгууллага	81	81	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2,878	2,932	(54)	101.9
620001	Удирдах ажилтан	140	134	6	95.7
620002	Гүйцэтгэх ажилтан	2,425	2,445	(20)	100.8
620003	Үйлчлэх ажилтан	257	257	-	100.0
620004	Гэрээт ажилтан	56	96	(40)	171.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,878	2,932	(54)	101.9
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	815	814	1	99.9
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3	2	1	66.7
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	22	22	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2,036	2,065	(29)	101.4
650010	Гэрээт ажилтан	-	27	(27)	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,341,428,209.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,079,383,339.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,780,723,939.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,315,108,294.67
210101	Үндсэн цалин	1,007,802,335.84
210102	Нэмэгдэл	12,193,829.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,575,722.74
210104	Урамшуулал	4,409,351.00
210105	Гэрээт ажлын хөлс	270,127,056.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,358,549.53
210201	Тэтгэврийн даатгал	161,257,868.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,998,787.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,780,075.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,019.95
210205	Эрүүл мэндийн даатгал	12,126,797.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,650,659.00
210301	Гэрэл, цахилгаан	18,632,229.00
210302	Түлш, халаалт	5,994,980.00
210303	Цэвэр, бохир ус	23,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	464,477,978.48
210401	Бичиг хэрэг	60,423,768.00
210402	Тээвэр, шатахуун	303,451,915.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,727,403.48
210404	Ном, хэвлэл	26,990,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	289,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,595,332.00
2105	Норматив зардал	41,144,491.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,474,300.00
210502	Хоол, хүнс	10,556,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,114,191.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	695,250,369.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	474,444,464.72
210602	Тавилга	28,392,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,818,866.00
210604	Урсгал засвар	185,594,938.28
2107	Томилолт, зочны зардал	180,638,015.00
210702	Дотоод албан томилолт	176,059,695.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,578,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,573,469,528.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,570,245,307.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	762,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,244.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	91,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	236,500.00
210807	Газрын төлбөр	2,047,077.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,626,054.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,092,339,287.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	208,286,767.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,298,659,399.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	239,987,813.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,009,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	230,978,213.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,058,671,586.82
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,671,586.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	262,044,870.00
2200	Дотоод эх үүсвэрээр	262,044,870.00
222001	Тоног төхөөрөмж	44,100,000.00
223001	Бусад хөрөнгө	43,590,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	174,354,870.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,336,909,069.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,336,909,069.39
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,223,234,060.41
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	924,084,057.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,120,148,925.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,069,442,026.18
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(4,519,140.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,586,419.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,067,279.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого хийх, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Ц.Цэрэнхүү, Г.Мөнхчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/1481 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтайг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны “Төсвийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан 17 байгууллага, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, нийт 130.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 144 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт 80.0 хувьтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг MNS6817-4:2020 стандартын дагуу тодорхойлохдоо суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 121,212.5 сая төгрөгийн 2 хувь буюу 2,424.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 17,403.9 сая, эцсийн үлдэгдэл 19,140.1 сая төгрөг болж, 1,736.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	13.3	0.9	(12.4)
Банканд байгаа бэлэн мөнгө	17,390.7	19,139.2	1,748.6
Дүн	17,403.9	19,140.1	1,736.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	832.8	586.6	(246.2)
ТӨҮГ болон ОНӨҮГ	16,571.1	18,553.5	1,982.4
Дүн	17,403.9	19,140.1	1,736.2

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн 19,140.1 сая төгрөгийн үлдэгдэл нь нэмэлт санхүүжилтийн харилцахад 11.1 сая төгрөг, арилжааны банкны харилцахад 625.4 сая, Төрийн сангийн харилцах дансанд 18,502.7 сая төгрөг тус тус байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл дэх 17,927.6 сая төгрөг нь байгалийн нөхөн сэргээх баталгаа бөгөөд нийт мөнгөн хөрөнгийн 93.6 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 1,139.3 сая /БОАЖЯ/
- Ээлжийн амралтын нөхөн олговор, цалинг давхардуулан олгосон 4.3 сая /Говийн их ДЦГХЗ/, Тэтгэмжээс НДШ, ХХОАТ суутгаагүй 2.5 сая /Хан хэнтийн УТХГХЗ/
- Ажиллагсдаас цалингийн урьдчилгааг суутгаагүй, авлагаар бүртгээгүй 1.1 сая /Баянхонгор аймгийн ЦУОШТ/ Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын /орон нутгийн/ төсөвт татан төвлөрүүлээгүй 1.5 сая /Баянхонгор аймгийн ЦУОШТ /
- Цалингийн зардлын хэмнэлтээс унаа, хоолны хөнгөлөлтөд зориулалт бусаар зарцуулсан 58.2 сая /Баян Өлгий аймгийн ЦУОШТ/, Ахмадын сангаас үр ашиггүй зарцуулсан 2.0 сая /Говь Сүмбэр аймгийн ЦУОШТ/, Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын үндсэн цалин бууруулаагүй 2.9 сая /Булган аймгийн ЦУОШТ/

- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 8.3 сая /Хэнтий аймгийн УЦУОШТ/
- Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд анхан шатны баримтаас дутуу тайлагнасан 8.3 сая /Дундговь аймгийн ЦУОШТ/
- Кассын тайланг сангийн яамнаас баталсан загвар маягт, аргачлалын дагуу гаргаагүй 1.0 сая /Сэлэнгэ аймгийн ЦУОШТ/

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 3,825.1 сая, эцсийн үлдэгдэл 2,138.4 сая төгрөг болж, 1,686.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.5	6.8	4.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2		(0.2)
Татаас, санхүүжилтийн авлага	3,413.4	1,756.1	(1,657.3)
Дансны авлага /ТӨҮГ/	25.6	25.6	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	18.6	2.8	(15.8)
Бусад авлага	364.8	347.1	(17.7)
Дүн	3,825.1	2,138.4	(1,686.7)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,816.6	1,527.6	(1,289.0)
Төсөл/ сан	947.2	571.8	(375.4)
ТӨҮГ болон ОНӨҮГ	61.3	39.0	(22.3)
Дүн	3,825.1	2,138.4	(1,686.7)

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 353.0 сая төгрөгийн дараах авлагууд байна.

Үүнд:

- Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буугдсан “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ын 25.6 сая төгрөг;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2015 онд татан буугдсан Цэвэр агаар сангаас шилжиж ирсэн 311.5 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- ОББҮХ-ны тайланд 298.5 сая, БОАЖЯ-ны тайланд 10.8 сая, нийт 309.3 сая төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй;
- Ойн судалгаа хөгжлийн төв өмнөх оноос дамжиж ирсэн болон тайлант онд үүссэн нийт 9.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Сэлэнгэ голын сав газрын захиргаа 2016 онд үүссэн 2.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 29,720.3 сая, эцсийн үлдэгдэл 27,516.9 сая төгрөг болж, 2,203.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	29,717.3	27,513.4	(2,203.9)
Томилолтын урьдчилгаа	3.0	3.5	0.5
Дүн	29,720.3	27,516.9	-2,203.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	29,676.2	27,227.6	(2,448.6)
Төсөл/ сан	5.6		(5.6)

ТӨҮГ болон ОНӨҮГ	38.5	289.3	250.8
Дүн	29,720.3	27,516.9	-2,203.4

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2011-2019 оны агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлуудын урьдчилгаа санхүүжилт 12,291.4 сая төгрөг байна. Дээрх үлдэгдэл нь ажлыг хүлээн аваагүй, гэрээг дүгнээгүй, 2-оос дээш жил дамнан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилт, урьдчилгаатай холбоотой үүссэн тооцоо байна.

Туул голын сав газрын захиргааны хэрэгжүүлж байгаа “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн 2019 онд шилжүүлсэн урьдчилгаа санхүүжилт 548.8 сая төгрөгийн үлдэгдэл тус тус байна.

Ойжуулалт хөтөлбөрийн төсвөөс 2014 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний 195.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 9,405.5 сая, эцсийн үлдэгдэл 13,346.0 сая төгрөг болж, 3,940.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	4,167.3	6,744.7	2,577.4
Дуусаагүй үйлдвэрлэл	354.4	21.9	(332.5)
Бэлэн бүтээгдэхүүн	4.1	5.6	1.5
Хангамжийн материал	4,736.6	6,422.3	1,685.7
Биологийн хөрөнгө	63.0	65.0	2.0
Мал амьтад	80.1	86.5	6.3
Дүн	9,405.5	13,346.0	3,940.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,919.4	13,246.0	4,326.6
Төсөл/ сан	5.3	9.1	3.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	480.8	90.9	(389.9)
Дүн	9,405.5	13,346.0	3,940.5

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авалтаар 7,636.2 сая, хандивын 742.8 сая, шилжиж ирсэн 7,835.6 сая төгрөгийн дүнгээр нэмэгдэж, худалдаж, зарцуулсан 5,791.8 сая, шилжүүлсэн 7,111.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 29,663.4 сая, агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн батлагдсан төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11,795.9 сая, Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын 30.0 сая төгрөгийн хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Говийн их ДЦГХЗ нэмэлт санхүүжилтийн төсвөөс худалдан авсан 1.4 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан;
- Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдээгдлээс 7.7 сая бараа материал худалдан авч нөөцөлсөн /Ховд ЦУОШТ 1.2 сая, Их богд БЦГХЗ 6.5 сая/
- УЦУОШГ гүйцэтгэгч "Гангануур өргөө" ХХК-д барилгын ажлын санхүүжилтэд 39.9 сая төгрөгийг олгосон боловч 21.1 сая төгрөгөөр бүртгэсэн;
- Говийн их ДЦГХЗ тушаал, шийдвэргүйгээр 3.2 сая төгрөгийн бараа материал акталсан;
- Тайлант онд худалдан авсан 6.1 сая төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан /Мөнххайрханы БЦГХЗ-4.2 сая, Хөвсгөл ЦУОШТ-1.9 сая/
- Хар нуур, Ховд голын СГЗ анхан шатны баримтгүйгээр 1.3 сая төгрөгийн шатахууны зардлын гүйлгээ хийсэн;
- Богдхан уулын ДЦГХЗ-ны хөрөнгийн тооллогоор 43.5 сая төгрөгийн 58 толгой адуу дутагдсан;

- ОСХТ тайлант онд 6.1 сая төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардал гарсан, Сэлэнгэ аймгийн ЦУОШТ зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардлын ангилал зөрчин 1.5 сая төгрөгийн зарцуулсан.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 62,876.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 75,295.4 сая төгрөг болж, 12,419.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	30,723.3	33,747.2	3,023.9
Авто тээврийн хэрэгсэл	4,554.9	6,359.8	1,804.9
Машин тоног төхөөрөмж	6,955.4	13,336.2	6,380.8
Тавилга эд хогшил	1,084.9	1,595.7	510.8
Зам гүрийн барилга байгууламж	2.3	1.9	(0.4)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	0.7	0.6	(0.1)
Түүх соёл, музейн зүйлс	1,232.8	1,210.3	(22.5)
Бусад үндсэн хөрөнгө	1,310.9	1,837.7	526.8
Ном	13.5	4.6	(8.9)
Программ хангамж	87.9	219.7	131.8
Бусад биет бус хөрөнгө	16,909.4	16,981.7	72.3
Дүн	62,876.0	75,295.4	12,419.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	53,558.5	66,421.3	12,862.8
Төсөл/ сан	96.1	88.2	(7.8)
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,221.4	8,785.8	(435.6)
Дүн	62,876.0	75,295.4	12,419.4

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 796.3 сая, балансаас балансад шилжүүлсэн 7,956.1 сая, үнэ төлбөргүй хандиваар ирсэн 2,561.7 сая, дахин үнэлгээгээр 30.9 сая төгрөгийн дүнгээр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 1,153.8 сая, худалдсан 132.9 сая, акалсан 3,764.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Тендер шалгаруулалтыг цахимаар гүйцэтгээгүй 4,504.6 сая /БОАЖЯ ОББҮХ/
- Тендерийн хэмнэлтээс төлөвлөгөөнд тусгаадаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан 40.6 сая /ОСХТ/
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй 12.7 сая /Дорноговь аймгийн ЦУОШТ/
- Үндсэн хөрөнгийг актлах, данснаас хасахдаа холбогдох журмыг зөрчсөн 79.1 сая / ОСХТ-52.0 сая/, Хөх сэрхийн нурууны ДЦГХЗ-27.1 сая/
- Байгууллагаас шилжиж ирсэн 4 мотоцикл бүртгэлгүй, гэрчилгээ аваагүй 5.9 сая сая /Баянхонгор аймгийн ЦУОШТ/
- Элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл, шийдвэр гаргуулаагүй 131.8 сая /УБ УЦУОШТ-22.5 сая /Монгол Ус ТӨААТҮГ-109.3 сая/
- ОББҮХ-ны санхүүгийн тайланд өмнөх онуудын 18 гэрээний хэрэгжих хугацаа хэтэрсэн, дүгнэж, тооцоо нийлээгүй, урьдчилж төлсөн зардалд бүртгэсэн 12.3 сая /БОАЖЯ/
- Байгууллагын батлагдсан төсвөөс зохих шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн 1.2 сая /БУ ЦУОШТ/
- Хандив, тусламжаар ирсэн 2 автомашиныг хөрөнгөд бүртгээгүй, үйл ажиллагаандаа ашиглаж 4.8 сая төгрөгийн зардал гаргасан //Богдхан уулын ДЦГХЗ/
- Үндсэн хөрөнгийн шаардлага хангаагүй хөрөнгийг ангилал зөрчин бүртгэсэн 6.1 сая /Горхи Тэрэлжийн БЦГХЗ/
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй 78.4 сая /Дархан-Уул аймгийн ЦУОШТ/

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 17,757.7 сая, эцсийн үлдэгдэл 19,129.2 сая төгрөг болж, 1,371.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	614.3	825.9	211.6
Ажилчидтай холбогдсон өглөг	8.4	55.9	47.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.6	0.7	(3.9)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	4.0		(4.0)
Бусад өглөг	597.3	769.3	(172.0)
Урьдчилж орсон орлого	17,143.4	18,303.3	1,159.9
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	16,354.0	17,927.7	1,573.7
Бусад урьдчилж орсон орлого	789.4	375.6	(413.8)
Нийт дүн	17,757.7	19,129.2	1,371.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	16,702.4	18,455.6	1,753.2
Төрийн сан	24.3		(24.3)
Төрийн сан	1,031.0	673.6	(357.4)
ДҮН	17,757.7	19,129.2	1,371.5

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буугдсан “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ын 32.7 сая, Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2014 онд үүссэн 54.4 сая, мөн тайлант онд цар тахлын улмаас хойшилсон 7 байгууллагатай холбогдох 177.0 сая төгрөгийн өглөг, ойжуулалт хөтөлбөрийн 2014 онд үүссэн 263.6 сая төгрөгийн олон жилийн насжилттай өглөг байна.

Урьдчилж орсон орлого дансанд 2006 оноос үүссэн байгалийн нөхөн сэргээлтийн баталгаа дансны үлдэгдэл 17,927.6 сая төгрөг бүртгэлтэй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 133,558.6 сая, эцсийн үлдэгдэл 159,799.8 сая төгрөг болж, 26,241.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал			
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	43,627.2	43,900.1	272.9
Өмч /төрийн/ ТӨҮГ	8,087.2	7,910.9	(176.3)
Хуримтлагдсан үр дүн	75,235.5	101,429.9	26,194.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,608.7	6,558.9	(49.8)
Дүн	133,558.6	159,799.8	26,241.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	122,925.0	150,740.7	27,815.7
Төсөл, сан	1,029.9	(98.7)	(1,128.6)
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,603.7	9,157.8	(445.9)
Дүн	133,558.6	159,799.8	26,241.2

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс 272.9 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрыг шинээр үүсгэн байгуулсантай холбоотой байна.

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төвийн 176.2 сая төгрөгийн залруулга нь 2020 оны аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд гарсан дүн болно. Дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан, үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 49.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 464,255.45 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хүргүүлсэн төсвийн төслийг 288,000.0 сая төгрөгөөр бууруулж 176,255.45 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн санхүүжилтэд 157,769.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 138,671.1 сая төгрөгийг урсгал зардалд, 19,098.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 157,473.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 295.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 132,024.4 сая төгрөгийг улсын төсвөөс шилжүүлж, 25,449.3 сая төгрөгийн дутуу санхүүжилттэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 370.9 сая төгрөг бүрдүүлснээр батлагдсан төсөв 104.5 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд Цаг уур, орчны шинжилгээний газруудын цаг агаарын мэдээний, ойн үрийн, нөхөн төлбөрийн орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсвийн нийтдээ 132,024.4 сая төгрөг буюу 83.8 хувийг зарцуулж, 25,268.6 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дараах зардлуудыг батлагдсан төсвөөс дутуу зарцуулсан байна. Үүнд:

- Бараа, ажил үйлчилгээний зардал 22,056.8 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсанд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын гүйцэтгэл нөлөөлсөн;
- Хөрөнгө оруулалтын 30 төсөл, арга хэмжээнд 17,639.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 14,655.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/61 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн захирагч нарт эрхээ шилжүүлсэн 7,935.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 7,411.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 373.2 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн;
- Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс Тэрхийн цагаан нуурын экосистемийг хамгаалах далан /Архангай, Тариат сум/, Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл, Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусламж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга байгууламж, өвлийн спортын талбай, Монгол Улсын "Төв цэг"-ийн засвар, тохижилтын ажлууд хийгдээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Хандив тусламж, гадаадын төсөл хөтөлбөрөөс 6,223.2 сая, Засгийн газрын нөөц сангаас 924.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,082.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,078.9 сая, нийт 11,968.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 7,752.5 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 239.9 сая, хөрөнгийн зардалд 262.04 сая, нийт 8,149.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,058.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний 121 дүгээр тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрыг шинээр үүсгэн байгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 12-ны А/79 дүгээр тушаалаар хамгаалалтад авсан газар нутаг нэмэгдсэнээр 159 орон тоо батлагдаж, гэрээ ажилтнуудын цалинг SDG тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд нэмэлт санхүүжилт олгон шийдвэрлэжээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 чиглэлийн 16 ажлаас жилд хүлээн авах гадаадын жуулчны тоо, хувь нь зорилтот түвшинд хүрээгүй байна.

Энэ нь Дэлхий дахинд “Ковид-19” цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улс өндөржүүлсэн бэлэн байдал зарласнаас гадаад жуулчдын урсгал бүрэн зогссон. Судалгаагаар аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй 600 гаруй зочид буудал, 310 гаруй тур оператор компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. Монгол Улсын аялал жуулчлалын салбар 2020 онд 1.6 их наяд төгрөгийн алдагдлыг хүлээж, гадаадын жуулчдын тоо 93 хувиар буурсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын 2017 оны 199, 2020 оны 115, 211 дүгээр тогтоолуудын дагуу ОББҮХ нь 2020 оны 05 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан 15,851.03 сая төгрөгийн төсөв батлагдаж, ЭХЯ-ны харьяа газруудад бүрэн шилжүүлсэн ба тус салбарын 14 төрийн өмчит компани 2017-2020 онд 7,319.5 сая төгрөгийн авлага хуримтлагдсан тооцоо судалгаа байна. ОББҮХ тайлант жилийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулж батлаагүй, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдвэргүй байна.

Туул голын сав газрын захиргааны 2019 онд хэрэгжүүлж эхэлсэн “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн ажлын даалгаварт тусгасан 5 дахь усан санг гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд хийгээгүй, хаягдал бохир усыг цэвэршүүлэх туршилтын ажлыг технологийн дагуу бүрэн хийж, үр дүнг хүлээлгэн өгөөгүйгээс байгууламж ашиглалтад орох боломжгүй нөхцөл үүссэн байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 143 мэдээлэл байршуулахаас 137 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7.9 сая төгрөгийн 1 акт, 553.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ОББҮХ-ны санхүүгийн тайлангийн урьдчилгаа дансанд бүртгэлтэй өмнөх онуудын гэрээний хэрэгжилт, БОАЖЯ-ны бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэлийг үзэх шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 89 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 8 байгууллагад итгэл үзүүлж, 64 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй, 5 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан, 2 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,509.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,109.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1,155.3 сая төгрөгийн зөрчилд 17 акт тогтоож, 5,952.7 сая төгрөгийн зөрчилд 35 албан шаардлага, 7,292.4 сая төгрөгийн зөрчилд 76 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 592.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 295.6 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 296.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Говь-Алтай аймаг дахь Монгол элсний байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг аудитад хамруулж, баталгаажуулалгүй нэгтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн ажлын албаны батлагдсан төсвөөс 17.2 сая төгрөгөөр автомашин худалдан авсан боловч жолооч нь зам тээврийн осол гаргаж ашиглах боломжгүй болсон" зөрчилд өгсөн албан шаардлага, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буугдсан Аялал жуулчлалын үндэсний төвийн 64.1 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэх" албан шаардлагыг тус тус биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хугацаанд түүвэрт хамрагдсан байгууллагуудын талаар

1. Хөрөнгө оруулалтын гэрээний барьцааны үлдэгдэл 214.2 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалт, их засварын 2020 оны санхүүгийн тайлангаарх 127.5 сая төгрөгийн аж ахуйн материалын хагас жилийн болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн материалын хагас жилийн болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж байх.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аялал жуулчлалын хөгжлийн төв тайлант онд 35.3 сая төгрөгийн цалингийн өр, 105.5 сая төгрөгийн бусад өр, 19.6 сая төгрөгийн НДШ-ийн өглөг, 9.0 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөг, нийт 169.4 сая төгрөгийн өглөг үүсгэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөг үүсгэхгүй байх, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, барагдуулах ажлыг зохион байгуулах.

3. Удирдлага болон дээд шатны төсөв захирагчийн дотоод хяналт

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 89 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 8 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 64 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй, 5 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан, 2 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна. Аудитаар нийт 15,509.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,109.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1,155.3 сая төгрөгийн зөрчилд 17 акт тогтоож, 5,952.7 сая төгрөгийн зөрчилд 35 албан шаардлага, 7,292.4 сая төгрөгийн зөрчилд 76 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагад илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	БОАЖС-дын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд	Аудитад хамрагдсан хэлбэр						Алдаа зөрчлийн ангилал								Аудитын илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн			
		Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Аудит хийгдээгүй	Дүгнэлт			Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитаар өгсөн зөвлөмж		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга					
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17		
I. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ																			
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд					1						2	81.3	1	-	0	-	3	81.3
2	Хөрөнгө оруулалт, их засварын зардал		1									1	214.2	1	0.1	0	-	1	214.3
3	Нөхөн сэргээлтийн баталгаа		1									0	-	0	-	-	-	-	-
3	ДҮН	0	2	0	0	1	0	0	-	3	295.5	2	0.1	0	-	5	295.6		
II. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																			
1	Цаг уур, орчны шинжилгээний газар				1							1	21.2	1	22.5	0	-	2	43.7
1	ДҮН	0	0	0	1	0	0	0	-	1	21.2	1	22.5	0	-	2	43.7		
III. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																			
1	Аялал жуулчлалын хөгжлийн төв		1									1	169.4	0	-	-	-	1	169.4
2	Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ						1					1	500.8	0	-	0	-	1	500.8
3	Монгол Ус ТӨААТҮГ					1		1	0.03	0	-	3	109.3	3	56.6	7		7	165.9
3	ДҮН	0	1	0	0	1	1	1	0.03	1	500.8	4	278.7	3	56.6	9	836.1		
IV. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																			
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам					1		1	1,139.3	2	4,504.7	2	6,637.5	0	-	-	-	5	12,281.4
2	Богдхан уулын ДЦГХЗ				1			0	-	1	239.5	2	48.4	0	-	-	-	3	287.9
3	Говийн бага ДЦГХЗ	1						0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-
4	Говийн их ДЦГ-ын А хэсгийн ХЗ				1			3	2.9	1	3.2	1	-	1	27.7	6		6	33.8
5	Говийн их ДЦГ-ын Б хэсгийн ХЗ				1			2	4.7	2	-	1	8.5	1	5.7	6		6	18.9
6	Говь гурван сайхны БЦГХЗ				1			0	-	0	-	2	-	0	-	-	-	2	-
7	Горхи Тэрэлжийн БЦГХЗ				1			0	-	1	10.9	2	6.2	0	-	-	-	3	17.1
8	Дарьгангын БЦГХЗ	1						0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-
9	Дорнод ДЦГХЗ				1			0	-	2	38.7	0	-	0	-	-	-	2	38.7

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Зэд Хантай бүтээлийн нурууны ХЗ		1				0	-	0	-	0	-	0	-	0	-
11	Их богдын БЦГХЗ			1			0	-	0	-	3	6.7	0	-	3	6.7
12	Их газрын чулууны БЦГХЗ		1				0	-	0	-	0	-	0	-	0	-
13	Монгол Алтайн нурууны УТХГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
14	Монгол Элсний БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
15	Мөнххайрханы БЦГХЗ			1			1	0.3	0	-	1	4.2	0	-	2	4.5
16	Мянган угалзатын нурууны БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
17	Нөмрөгийн ДЦГХЗ			1			0	-	1	-	0	-	0	-	1	-
18	Онон балжийн БЦГХЗ			1			0	-	1	0.4	2	43.1	0	-	3	43.5
19	Орхоны хөндийн БЦГХЗ	1					0	-	0	-	0	-	0	-	0	-
20	Отгонтэнгэр ХЗ			1			0	-	0	-	1	-	0	-	1	-
21	Тарвагатайн БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
22	Тужийн нарсны БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	1	2.1	1	2.1
23	Увс нуурын ай савын ДЦГХЗ	1					0	-	0	-	0	-	0	-	0	-
24	Улаан тайгын БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
25	Хан хэнтийн УТХГХЗ			1			0	-	1	5.0	1	2.5	0	-	2	7.5
26	Хангай нурууны БЦГХЗ	1					0	-	0	-	0	-	0	-	0	-
27	Хан хөхийн нурууны ХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
28	Хар ус нуурын БЦГХЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
29	Хөвсгөлийн УТХГХЗ			1			0	-	0	-	1	-	0	-	1	-
30	Хөгнө Тарнын БЦГХЗ		1				0	-	0	-	0	-	0	-	0	-
31	Хөх сэрхийн нурууны ДЦГХЗ			1			0	-	0	-	2	27.1	0	-	2	27.1
32	Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ				1		0	-	2	92.6	2	15.3	0	-	4	107.9
33	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв			1			0	-	1	10.5	0	-	0	-	1	10.5
34	Алтайн өвөр говийн СГЗ			1			0	-	0	-	1	53.2	0	-	1	53.2
35	Бөөнцагаан Орог нуурын СГЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
36	Буйр нуур Мэнэнгийн талын СГЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
37	Галба Өөш Долоодын СГЗ	1					0	-	0	-	0	-	0	-	0	-
38	Дэлгэрмөрөн Шишхэд голын СГЗ			1			0	-	0	-	1	-	0	-	1	-
39	Идэр голын СГЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
40	Онги таац голын СГЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-
41	Онон Улз голын СГЗ			1			0	-	0	-	0	-	0	-	0	-

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

42	Орхон Чулуут голын СГЗ				1			0	-	0	-	2	-	0	-	2	-
43	Сэлэнгийн голын СГЗ					1		0	-	0	-	3	52.1	0	-	3	52.1
44	Туул голын СГЗ				1			0	-	1	-	0	-	0	-	1	-
45	Увс нуур Тэсийн голын СГЗ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
46	Умард говийн Гүвээт Халхын дундад талын СГЗ	1						0	-	0	-	0	-	0	-	0	-
47	Үенч Бодонч Булган голын СГЗ	1						0	-	0	-	0	-	0	-	0	-
48	Хануй голын СГЗ				1			0	-	0	-	2	0.3	0	-	2	0.3
49	Хар нуур Ховд голын СГЗ				1			0	-	0	-	3	1.3	0	-	3	1.3
50	Хараа Ерөө голын СГЗ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
51	Хөвсгөл Эгийн голын СГЗ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
52	Хүйсийн говь Цэцэг нуурын СГЗ				1			0	-	1	0.7	0	-	0	-	1	0.7
53	Хэрлэн голын СГЗ					1		0	-	1	-	1	98.5	0	-	2	98.5
54	Хяргас нуур Завхан голын СГЗ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
55	Архангай аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
56	Баян-Өлгий аймаг УЦУОШТ				1			0	-	1	58.2	1	-	0	-	2	58.2
57	Баян хонгор аймаг УЦУОШТ				1			2	1.7	1	6.0	1	-	2	2.0	6	9.7
58	Булган аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	3	4.2	0	-	3	4.2
59	Говь-Алтай аймаг УЦУОШТ				1			0	-	1	-	1	6.8	1	0.2	3	7.0
60	Говь Сүмбэр аймаг УЦУОШТ				1			1	0.7	2	2.0	1	-	2	64.1	6	66.8
61	Дархан аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	4	80.4	0	-	4	80.4
62	Дорнод аймаг УЦУОШТ			1				0	-	1	-	0	-	0	-	1	-
63	Дорноговь аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	1	12.7	0	-	1	12.7
64	Дундговь аймаг УЦУОШТ				1			0	-	1	6.8	0	-	3	105.8	4	112.6
65	Завхан аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	3	-	0	-	3	-
66	Орхон аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	1	-	0	-	1	-
67	Өвөрхангай аймаг УЦУОШТ				1			0	-	1	-	0	-	0	-	1	-
68	Өмнөговь аймаг УЦУОШТ				1			1	0.4	0	-	3	8.5	1	519.9	5	528.8
69	Сүхбаатар аймаг УЦУОШТ				1			2	3.2	0	-	0	-	0	-	2	3.2
70	Сэлэнгэ аймаг УЦУОШТ				1			0	-	1	1.5	1	1.1	0	-	2	2.6
71	Төв аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	2	3.4	3	318.6	5	322.0
72	Увс аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	0	-	0	-	0	-
73	Ховд аймаг УЦУОШТ				1			1	1.2	1	-	1	-	0	-	3	1.2
74	Хөвсгөл аймаг УЦУОШТ				1			0	-	0	-	2	1.9	0	-	2	1.9

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

75	Хэнтий аймаг УЦУОШТ				1			0	-	1	8.3	3	0.5	0	-	4	8.8
76	Улаанбаатар УЦУОШТ		1					0	-	0	-	0	-	0	-	0	-
77	УЦУОСМХүрээл эн				1			1	0.9	1	441.8	5	-	1	6.6	8	449.3
78	БОХЗТЛ				1			1	0.0	2	-	1	-	0	-	4	0.0
79	Нислэгийн цаг уур		1					0	-		-	0	-	0	-	0	-
80	ЦУОШГ		1					0	-		-	0	-	0	-	0	-
80	ДҮН	8	6	2	60	4	0	16	1,155.3	32	5,430.8	70	7,124.4	16	1,052.7	134	14,763.1
V. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН																	
1	Байгаль орчин, уур амьсгалын сан				1					1		2	36.2			3	36.2
1	ДҮН	0	0	0	1	0	0	0	-	1	-	2	36.2	0	-	3	36.2
VI. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖ																	
1	НҮБ-ын УАӨДЗТББҮЧБ төсөл				1							0	-			0	-
2	НҮБ-ын УАӨСКХҮДТ, ШНХТБАХХ төсөл				1							0	-			0	-
2	ДҮН	0	0	0	2	0	0	0	-	0	-	0	-	0	-	0	-
90	НИЙТ ДҮН	8	9	2	64	6	1	17	1,155.3	38	6,248.2	79	7,462.0	19	1,109.4	153	15,974.8

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Акт, албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Дундаж цалин хөлсийг буруу тодорхойлсноос нэр бүхий 3 ажилтанд ээлжийн амралтын олговрыг 279,685.9 төгрөгөөр, түүнээс тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 32,320.7 төгрөгөөр тус тус илүү тооцож олгосон байна.	0.03	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Г.Билэгсайхан, М.Энхтүвшин
2	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүгийн тайланд агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 1,139,268.7 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.	1,139.3	Төлбөрийн акт	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
3	Ажилчдад 834.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг дутуу бодож олгосон нь Байгууллагын даргын 2020 оны Б/23, Б/39 дугаар тушаал, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, АДБОУС 1250 заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.	0.8	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Ч.Баярбат, Б.Нямсүрэн
4	Тээвэр шатахууны зардлыг тулган баталгаажуулахад 456.0 мянган төгрөгийн шатахууныг давхардуулан олгосон, 226.2 мянган төгрөгийн шатахууныг нормоос илүү бодож олгосон	0.7	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Ч.Баярбат, Б.Нямсүрэн
5	Нэмэлт санхүүжилтийн дансанд орсонд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанд хийгдэх хилийн багана, тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийн самбар, нэвтрэх хаалга барих ажлын 1,400.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг шууд зардлаар тайлагнасан	1.4	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Ч.Баярбат, Б.Нямсүрэн
6	Ээлжийн амралтын нөхөн олговор, цалинг давхардуулан 415.5 мянган төгрөгийг илүү олгосон.	0.4	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	О.Ганбаатар, А.Бүнчиндагва
7	Төсвөөс 821.9 мянган төгрөгийн акт төлсөн, Тайланд онд 2,981.2 мянган төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудасны, анхан шатны баримтгүй зарцуулсан, нярвын тайлангийн түлшний үлдэгдэл нягтлан бодох бүртгэлээс 374.0 мянган төгрөгөөр, өвс тэжээлийн үлдэгдэл 102.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	4.3	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	О.Ганбаатар, А.Бүнчиндагва

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

8	Байгууллагын нүүрс татан авахдаа тухайн сумын сургууль цэцэрлэг мөрдөж байгаа үнээс өндөр үнээр нийлүүлсэн.	0.3	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	М.Одхүү, Б.Батцэцэг
9	Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020.03.13-ны өдрийн Б/39 тоот тушаалаар Ч.Оюунчимэгт албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад 4 сарын цалингаас суутгаж 5 сард суутган тооцолгүй бүтэн цалингаар тооцож 289.7 мянган төгрөг илүү олгосон. Мөн сахилгын шийтгэлийн хугацаа дуусгавар болоогүй байхад цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 7-р сарын А/149 тоот тушаалаар 2020 оны хагас жилийн үр дүнгийн урамшуулал нэг сарын цалингийн 40 хувиар тооцож 292.8 мянган төгрөг тус тус олгосон байна.	0.6	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
10	Ажиллагсдын цалингийн урьдчилгааг суутган тооцон эсэхийг тулган шалгахад 5 ажилтнаас 1,070.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.	1.1	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
11	Нягтлан бодогч байгууллагын даргын тушаалгүйгээр эрх мэдэл, албан тушаалаа ашиглан 679.1 мянган төгрөгийн балансын урамшууллыг тооцож авсан, байгууллагын удирдлагаас хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, урамшуулал олгох тушаалыг нөхөж гаргасан байна.	0.7	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Э.Энх-Од, Б.Ариунжаргал
12	Түр орлон ажиллаж байгаа 1 ажилтанд албан тушаалын цалинг 54,578 төгрөгөөр илүү, сануулах арга хэмжээ авсан 3 ажилтанд нийт 376,555 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	0.4	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Г.Дуламцоо, Т.Баярмаа
13	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү бодож олгосон.	1.7	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Х.Энхбаяр, Ц.Цацралтуяа
14	Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй бодит бус авлага үүсгэсэн.	1.5	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Х.Энхбаяр, Ц.Цацралтуяа
15	Сумдын ертөөний нүүрсний норм тооцож тооцоо бодоогүй бөөнд нь зарлагдсан нүүрс асаах аргалыг их хэмжээгээр нөөцөлсөн.	1.2	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	А.Энхзаяа, Б.Батчимэг
16	Ажилчдын цалингаас НДШ-ийг илүү, ХХОАТ-ын хөнгөлөлтийг буруу тооцоолсон, Хавсран ажилласны нэмэгдэл авч буй ажилчдын ур чадварын нэмэгдлийг 325.7 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, Ажилчдын дундаж цалин, хөлсийг буруу тооцоолсноос 43.0 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговрын илүү тооцож тус тус олгосон.	0.9	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Г.Сарантуяа, Ч.Ганчимэг
17	Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэр бүхий 2 ажилтанд албан томилолтын 44.0 мянган төгрөгийн нөхөн олговрыг илүү олгосон.	0.04	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва, Ч.Цэцэгдэлгэр
18	Хөрөнгө оруулалтын гэрээний барьцаа 214.2 сая төгрөгийн үлдэгдлийг санхүү бүртгэлд өглөгөөр тусгаагүй байна.	214.2	Албан шаардлага	Сайд Ерөнхий нягтлан бодогч	Н.Уртнасан, С.Лхам

19	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Говь-Алтай аймгийн "Монгол элсний байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй нэгтгэгдсэн байна.		Албан шаардлага	Сайд Ерөнхий нягтлан бодогч	Н.Уртнасан, С.Лхам
20	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн ажлын албаны батлагдсан төсвөөс 17.2 сая төгрөгөөр автомашин худалдан авсан боловч жолооч нь зам тээврийн осол гаргаж ашиглах боломжгүй болсон" зөрчилд өгсөн албан шаардлага, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буугдсан Аялал жуулчлалын үндэсний төвийн 64.1 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэх" албан шаардлагыг тус тус биелүүлээгүй байна.	81.3	Албан шаардлага	Сайд Ерөнхий нягтлан бодогч	Н.Уртнасан, С.Лхам
21	Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Халх гол сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилга барих гүйцэтгэгчээр "Гангануур өргөө" ХХК шалгарч 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр барилгын ажлыг хүлээлгэн өгөхөөр 49.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй УТ-2012/30 дугаартай барилга угсралтын ажлын гэрээг 2012 оны 6 дугаар сарын 5-нд байгуулсан байна. Гүйцэтгэгч компанид нийт 39.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч захиалагч байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газар 21.2 сая төгрөгөөр бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Жич: /уг барилгын зөвхөн газар шороо, суурийн ажил хийгдсэн байдалтай байна/	21.2	Албан шаардлага	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин, Д.Отгонбаяр
22	Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 27 мэдээллээс 500.8 сая төгрөгийн 25 мэдээллийг байршуулаагүй байна.	500.8	Албан шаардлага	Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын Төрийн өмчийн төлөөлөгч, Нягтлан бодогч	Ц.Баяр-Эрдэнэ, Д.Наран
23	Засгийн газрын 2017 оны 199, 2020 оны 115, 211 дүгээр тогтоолуудын дагуу ОББҮХ нь 2020 оны 05 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд зориулан 15,851.03 сая төгрөгийн төсөв баталж, ЭХЯ-ны харьяа газруудад бүрэн шилжүүлсэн боловч эрчим хүчний салбарын 14 төрийн өмчит компаниудад 2017-2020 онд 7,319.5 сая төгрөгийн авлага хуримтлагдсан тооцоо судалгаа байна. ОББҮХ тайлант жилийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулж батлаагүй, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдвэргүй байна.		Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

24	ОББҮХ 4,504.6 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг цахимаар гүйцэтгээгүй байна.	4,504.7	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганболд Д.Гантуяа
25	Шилэн дансны цахим хуудсан оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 239,468.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.	239.5	Албан шаардлага	Нягтлан бодогч	С.Одончимэг
26	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 3,216.8 мянган төгрөгийн бараа материалыг тушаалгүйгээр акталсан.	3.2	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Баярбат, Б.Нямсүрэн
27	Амралт, цалин давхардуулан илүү олгодог, жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтгүй шатахуун зарцуулдаг, төсвөөс төлбөрийн акт төлдөг зөрчлүүдийг давтан гаргаж өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.		Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	О.Ганбаатар
28	Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 1,594,182.6 мянган төгрөгийн 29 мэдээллээс 214,615.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байна.		Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	О.Ганбаатар, А.Бүнчиндагва
29	Шилэн дансны цахим хуудсан оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 9 мэдээлэл, 10,876.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.	10.9	Албан шаардлага	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга, Нягтлан бодогч	Ц.Дуламсүрэн, Б.Гандолгор
30	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 173 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой нийт 10 тушаал байршуулаагүй, биологийн олон янз байдалд дасан зохицох төслөөр ирсэн нийт 37,986.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	38.0	Албан шаардлага	Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны дарга, Нягтлан бодогч	Х.Дашдорж, М.Ганболор
31	Сахилгын шийтгэлийн 681.8 мянган төгрөгийг цалингийн хүснэгтийн суутгал хэсэгт суутган авсан байна.	0.7	Албан шаардлага	Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны дарга, Нягтлан бодогч	Х.Дашдорж, М.Ганболор
32	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулаагүй.		Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Чинбат, Д.Дулмаа
33	Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 384.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.	0.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	О.Цэндгомбо, Т.Доржханд
34	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулаагүй.	5.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	П.Оюунтунгалаг

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35	ТӨБЗГ-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/1653 дугаар бүхий зөвшөөрлөөр 48 нэрийн 45,148.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах, ТӨБЗГ-ын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 497 дугаар бүхий зөвшөөрлөөр 6,876.5 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг тракторыг үндсэн хөрөнгийн данснаас хасахдаа ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй байна.	52.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Цагаанхүү, П.Оюунгэрэл
36	Ойн судалгаа хөгжлийн төв нь тендерийн хэмнэлт 40,614.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2-т "төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.	40.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Цагаанхүү, П.Оюунгэрэл
37	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулаагүй.	10.5	Албан шаардлага	Нягтлан бодогч	О.Баярцэцэг
38	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулаагүй.		Албан шаардлага	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Оюунболд, О.Нэргүй
39	Эдийн засгийн ангилал зөрчин 708.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулсан.	0.7	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	С.Жаргалзаяа, Ш.Ганчимэг
40	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 1,832.5 мянган төгрөгийн шатахууны талонг тоолоогүй, бараа материалд бөөн дүнгээр бүртгэсэн.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Т.Баатарсүх, Б.Баяржавхлан
41	Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны батлагдсан төсөв унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 31,444.9 мянган төгрөгийн төсөвт батлагдсанаас гүйцэтгэлээр 89,635.6 мянган төгрөгийн зарцуулсан бөгөөд цалингийн зардлын хэмнэлтээс 58,190.7 мянган төгрөгийг төсвийн шууд захирагчийн тушаал болон төвийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан байна.	58.2	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	П.Жанаргүл, Т.Кеменгер
42	Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй УЦУОШГ-аас 2008, 2013 онд ирүүлсэн 2 мотоцикл 2014 онд техник импорт ХК-аас үнэ төлбөргүй олгосон 2 мотоцикл нийт 5,980.0 мянган төгрөгийн 4 мотоцикл байгууллагын нэр дээр бүртгэлгүй, гэрчилгээ аваагүй байна.	6.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энжаргал
43	Шилэн дансны цахим хуудсанд 6,500.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Н.Алтантуяа, С.Ундрах
44	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулах тухай 4 тушаалыг оруулаагүй, 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Э.Энх-Од, Б.Ариунжаргал

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

45	Ахмадын сангийн зардлаас 2,000.0 мянган төгрөгөөр 3 ахмадыг хүлээн авсан, хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, байгууллагын удирдлагын зүгээс хяналт тавьж төсвийг зөв зохистой зарцуулаагүй.	2.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Э.Энх-Од, Б.Ариунжаргал
46	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд дотоод аудит хийгдэж цалин хөлс, мал аж ахуй, тээвэр шатахууны зардалтай холбоотой материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн. Мөн санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай цалин, бараа материалын баримт материалыг Төрийн аудитын газраас шаардсан хуулийн хугацаанд гаргаж өгөөгүй зэргээс санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.		Албан шаардлага	Дарга	С.Энхтүвшин
47	Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд анхан шатны баримтаас дутуу тайлагнасан.	6.8	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Я.Мажаасүрэн, Д.Эрдэнэцэцэг
48	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шуудан холбооны зардалд зарцуулсан, Д.Үржинжаргал, М.Бямбасүрэн, Ц.Бумханд, А.Хашчулуун нарт тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг шилэн дансанд мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунчимэг, Р.Ичинхорлоо
49	Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 1,500.0 мянган төгрөгийг багаж тоног төхөөрөмжийн зардалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.	1.5	Албан шаардлага	Ус цаг, уур шинжилгээний төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Энхсэлэнгэ, Б.Гантуяа
50	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хот доторх нэг өдийн км-ийн нормыг хэтрүүлсэн, жолоочийн тооцоо бодоходоо машины спидометрийн заалт баримтлаагүй, жолоочийн зарим замын хуудсанд хэрэглэгчийн зөвшөөрсөн гарын үсэггүйтэй холбоотой 6,491.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	А.Энхзаяа, Б.Батчимэг
51	Эдийн засгийн ангилал зөрүүлэн ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 5,785.1 мянган төгрөг, цалинд олгосон 2,515.2 мянган төгрөг, нийт 8,300.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас зориулалт бусаар зарцуулан, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй илэрхийлж холбогдох заавар журмыг мөрдөөгүй байна.	8.3	Албан шаардлага	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Хэрлэнчимэг, Б.Амгаланбаатар
52	Тайлант хугацаанд оруулбал зохих 384,383.7 мянган төгрөгийн 4 орлогын мэдээлэл, 57,420.7 мянган төгрөгийн, 3 зардлын мэдээллийг байршуулаагүй, 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	441.8	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Г.Сарантуяа, Ч.Ганчимэг

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

53	Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн эрдэм шинжилгээний зориулалттай 7133 м.кв /0.7133га/ газраас 2014 м.кв /0.2014га/ газарт Цаг уур орчны шинжилгээний газар /ЦУШГ/-ын ажилчдын орон сууц 2014 онд баригдаж, газрын зориулалтад өөрчлөлт хийгдсэнийг Цаг уур орчны шинжилгээний газар /ЦУШГ/-т шилжүүлээгүй байна.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва, Ч.Цэцэгдэлгэр
54	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 148 мэдээллээс хугацаа хоцроосон 15 мэдээлэл, мөн 4 мэдээллийг байршуулаагүй байна.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва, Ч.Цэцэгдэлгэр
55	БОАЖС-ын 2017 оны А/338 "Б дугаар тушаалаар "Байгаль орчны эсрэг гэмт хэргийн улмаас болон захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах, шилжүүлэх шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг БОУАС-д шилжүүлсэн байна. Аудит хийх явцад гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг хадгалсан байдалтай танилцахад 466 нэрийн эд бараа, 1492.2 кг самар, 405.3 кг дэрвэгэр жиргэрүү, 1796 ш цагаан зээрийн эвэр зэрэг нь чанар байдлаа алдсан байдалтай байна. БОАЖС-ын 2019 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан байгалийн баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам"-ын 2.3-д "Зөвлөл нь холбогдох байгууллагаас шилжүүлэн ирүүлсэн байгалийн баялаг, эд зүйлийг хадгалах, үнэлэх, худалдан борлуулах, шилжүүлэх, устгах талаар хэлэлцэн, шийдвэр гаргана" гэсэн заалтын дагуу дээр дурдсан эд барааг журамд заасны дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.		Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Л.Баатарчулуун, П.Оюунтунгалаг
НИЙТ ДҮН		7,403.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 583/00110001

Улаанбаатар хот

С.АТ-2021/08/СТЭ-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн ажлын албаны батлагдсан төсвөөс 17.2 сая төгрөгөөр автомашин худалдан авсан боловч жолооч нь зам тээврийн осол гаргаж ашиглах боломжгүй болсон" зөрчилд өгсөн албан шаардлага, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн "Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буугдсан Аялал жуулчлалын үндэсний төвийн 64.1 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэх" албан шаардлагыг тус тус биелүүлээгүй байна.

Энэ нь оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, төсвийн ерөнхийлөн захирагчаас албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Отгонзул, Ерөнхий нягтлан бодогч С.Лхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 584/АД110001

Улаанбаатар хот

САГ-2021/08/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Говь-Алтай аймаг дахь Монгол элсний байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг аудитад хамруулж, баталгаажуулаагүй нэгтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгээгүй төсвийн захирагч нарт холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Отгонзул, Ерөнхий нягтлан бодогч С.Лхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 585/АА110001

Улаанбаатар хот

САГ-2021/08/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын гэрээний барьцааны үлдэгдэл 214.2 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлангаа гаргах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж, барьцаа хөрөнгийг үлдэгдлийг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Отгонзул, Ерөнхий нягтлан бодогч С.Лхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ